

Article

Education as a value

Odkhuu Sanduijav*

Department of Educational Studies, School of Humanities, Otgontenger University, Ulaanbaatar, Mongolia

*Corresponding author: odkhuu@otgontenger.edu.mn



<https://orcid.org/0009-0007-0730-6773>

Received: 09 March 2026. Accepted: 25 May 2026. Published online: 15 June 2026

Abstract

Values are the basis of education whereas the essence is that education is a carrier, a subsider, and a developer of the value. Through this meaning, education and value have unseparable interdependence and interrelations.

Value based education has become an important educational tendency tended to form a private person into a citizen that is conscious and recognizes his social roles and responsibilities.

Education has been understood as a value in different historical stages and has been in the center of philosophers giving a leading importance. Thus, it has touched an issue that an explanation of education as a value from theoretical and methodological points of view has become one of urgent modern problems.

Keywords: values, values orientation, beliefs, competencies, education, life skills



© 2026, Author(s). CC BY-NC 4.0. This license enables reusers to distribute, remix, adapt, and build upon the material in any medium or format for noncommercial purposes only, and only so long as attribution is given to the creator. <https://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>

Боловсрол үнэт зүйл болох нь

Сандуйжавын **Одхүү**

Доктор (Ph.D), профессор, Боловсрол судлалын тэнхим, Хүмүүнлэгийн сургууль, Отгонтэнгэр их сургууль, Улаанбаатар хот, Монгол Улс

Хураангуй

Арга зүй: Эх сурвалж, бодлогын баримт бичгийн харьцуулсан философи шинжилгээ, үнэт зүйлсийн судалгааны тайлан, энэ асуудлыг тусгайлан судалдаг зарим эрдэмтэн судлаачийн онол үзэл баримтлал, аргачлалыг ашиглаж, судалгааны герменевтик арга зүйд үндэслэсэн болно.

Судлагдсан байдал: Үнэт зүйлсийг боловсролын талаас судалсан Rokeach (1972), Kluckhohn, Hofstede (2001), McGuire, Garavan, Saha, & O'Donnell, (2006), (2003), Абушенко В. Л., Аванесов С. С., Багдасарьян Н. Г., Мануилов А.А., Некрасов А.Н., Пермякова, Т.В., Сластенин В.А., Чижаква Г.И. Шварц Ш, Шишов Ш.Е., Шохин В. К. зэрэг гадаадын эрдэмтдийн бүтээл байдаг. ОХУ-ын эрдэмтэн Данилова Е.А. (2015). Ценность образования в современном обществе
https://elib.bsu.by/bitstream/123456789/115336/1/sotsiologicheskaya_nauka_i_obrazovanie_p.66-68.pdf, Пермякова, Т.В. (1999). Образование как ценность. Диссертация на соискание кандидата философских наук, Шишов Ш.Е. (2015). Образование как ценность: структура и смыслы понятия
<https://cyberleninka.ru/article/n/obrazovanie-kak-tsennost-struktura-i-smysly-ponyatiya/viewer> нарын бүтээлийг онцлох байна.

Монгол судлаачдын тухайд Цэцэнбилэг Ц. (1998), Баатартогтох Ц. (2000), Баатартогтох Ц. (2000), Оюунцэцэг Н. (2020), Сэлэнгэ Х. (2004) Пүрэв О. (2021) нарыг юуны өмнө дурдаж болно.

Оксфордын философийн тайлбар толь (Blackbam, 1996)-д “үнэт зүйл гэдэг нь бие хүний сонголт хийхэд нөлөөлж, хөгжил дэвшил өөд чиглүүлдэг үзэл баримтлал бөгөөд субъектив, объектив хоёр талтай” хэмээсэн байдаг бол “Захиргааны шинжлэх ухааны нэр томъёоны тайлбар толь бичиг”-т “үнэт шилдэг чанар, аливаа зүйлийн үнэлэмжийн эх загвар болж чадах юмс үзэгдэл, объект, санаа бодлыг илэрхийлдэг ойлголт юм. Өөрөөр хэлбэл, хүмүүсийн хэрэгцээтэй, хүсүүштэй, итгэл найдвар болж буй зүйлийн ойлголт” (хууд.386) гэж тодорхойлжээ.

Бүх цаг үед боловсрол эрхэм үнэт зүйл байсан. Зарим үед тэргүүлэх ач холбогдолтой байсан. Ингэхдээ боловсролын өөрийнх нь мөн чанарт чухал гэж тооцогдож байсан зүйлүүд нь гүн өөрчлөлтөд өртөж байсан юм (Bourdieu, 2003). Тэр бүү хэл түүний чанарт тавигддаг шаардлагууд нь ижил томъёологддог хэдий ч төрөл бүрийн зорилготой байсан юм.

Үнэт зүйлсийн тухай үзэл баримтлал, ойлголт, тодорхойлолт олон байдаг.

Бид судалгаандаа үнэт зүйлс бол хүний бат тогтвортой үзэл бодол, итгэл үнэмшил болох оюуны хийгээд материаллаг эрхэм нандин, дээд эрхэмлэлт зүйлсийн нэгдэл, хүмүүсийн амин чухал хэрэгцээтэй, хүсүүштэй, итгэл найдвар, эрхэмлэл болж буй нандин зүйлсийн цогц гэсэн санааг баримталсан болно.

Үнэт зүйлс нь улс үндэстэнд төдийгүй хувь хүний амьдрал, үйл ажиллагаанд сэдэл, хөтөч, удирдамж болдог онцлогтой. Хүн бүр өөрийн үнэт зүйлстэй байж, түүнийгээ чанд мөрддөг, баримталдаг байх нь чухал.

Үнэт зүйлс (Values) нь түүхэн явцад нийгэмд болон хувь хүнд бүрэлдэн тогтсон нэн чухал, амьдралд хэрэгцээтэй, ач холбогдолтой, ашиг тустай эрхэм чухал зүйл мөн. Амьдрал, үйл ажиллагааны сэдэл, баримжаа болж байгаа эрхэмлэн дээдэлдэг оюуны болон материаллаг зүйлсийн талаарх нийгэмд хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, итгэл үнэмшлийн цогц. Хувь хүн, хамт олон, нийгэмд (хувь хүн, нийгэм соёлын орчин) хүлээн зөвшөөрөгдсөн, зан үйл, шийдвэр гаргалт, хандлагад нөлөөлдөг суурь итгэл үнэмшил, зарчим, хандлагын цогц.

Үнэт зүйл нь хувь хүний онцлог чанар болон бүлгийн өвөрмөц шинж чанарыг тусган илэрхийлдэг ойлголт бөгөөд боломжит хэв шинж, арга барил, үйл ажиллагааны үр дүнгээс сонголт хийхэд нөлөөлдөг хүсүүштэй байдлын тухай ойлголт Kluckhohn, Hofstede (2001) юм хэмээсэн бол McGuire, Garavan, Saha, & O'Donnell, (2006) нар “үнэт зүйл нь ямар ч тохиолдолд өөрчлөгдөшгүй тогтсон, бие хүний хувьд болон нийгмээрээ хүлээн зөвшөөрсөн итгэл үнэмшлүүдийн цогц” гэсэн тодорхойлолт өгчээ.

ОХУ-ын байгалийн шинжлэх ухааны Академийн академич, профессор Н.Г.Багдасарьян “боловсрол нь илүү ач холбогдол бүхий бусад үнэт зүйлсэд хүрэх чухал хэрэгсэл” болохыг онцлоод “боловсрол нь өөрийгөө илүү сайн ойлгох, амьдралын илүү өндөр түвшинд хүрэх механизм болж өгдөг”, “эрх мэдэл...олж авахад тусалдаг” (Багдасарьян Н.Г., 2008) хэмээсэн нь боловсрол суурь үнэт зүйл мөн болохыг тодорхойлсон хэрэг.

Боловсролыг хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйл гэж зүй ёсоор хүлээн зөвшөөрдөг. Энэ нь бидний цаг үеийн дэлхий дахины тулгамдсан асуудлын нэг болж хувирснаар нотлогдож байна. ЮНЕСКО-гийн Боловсролын төлөвлөлтийн олон улсын хүрээлэнгийн захирал Ж.Аллак: "бүх нийтийн суурь боловсрол нь олон улсын хамтын нийгэмлэгийн нэн тэргүүний зорилт"(Аллак Ж., 1993) болохыг онцолжээ. Гэвч боловсролыг хүн төрөлхтний нийтлэг үнэт

зүйл гэж ярих, уриалахдаа бид хүсэл мөрөөдөл ба бодит байдлын хооронд ялгаа байдаг болохыг анхаарах ёстой. Бүх зүйл хэвийн, эв нэгдэлтэй найрсаг мэт харагдавч дэлхий ертөнц ээдрээтэй, эгзэгтэй хэвээр байна.

Профессор В.П.Зинченко хувь хүний хувьд боловсрол нь үнэт зүйл болох талаар энгийнээр, оновчтой илэрхийлсэн байдаг: “...Боловсролын тогтолцооны гол үнэ цэнэ нь хүн бүрт боловсрол үнэт зүйл мөнийг нээн илрүүлэх, хөгжүүлэн төлөвшүүлэх, батжуулан бэхжүүлэх чадварт оршдог... Боловсролын үнэт зүйлийг хөгжүүлэх нь юуны өмнө хүн бүрийн амьдрал, хувь заяанд боловсролын үүрэг оролцоог анхаарч үзэх хэрэгтэй гэсэн үг юм” (Зинченко В. В., 1997).

Нэртэй социологич Э.Дюркгейм: “боловсрол нь хувь хүн, түүний ашиг сонирхлыг тусган илэрхийлэгч, ... нийгэм өөрийн оршин тогтнох нөхцөлийг бүрдүүлэгч хэрэгсэл мөн” (Дюркгейм & Гофман, 1995) хэмээсэн нь боловсрол амьдралын нөхцөл байдлыг бий болгох, өсгөн бэхжүүлэхэд нийгмийн хяналт, нөлөөллийн хэрэгсэл байсаар ирсэн, одоо ч байгаа, боловсролгүйгээр хамтдаа оршин тогтнох боломжгүй юм гэсэн санааг үнэт зүйлстэй холбон тайлбарлажээ.

Үнэт зүйлс нь ойлголт төсөөлөл болон эд зүйлийн суурь шинж чанарыг тусган илэрхийлдэг. Энэ утгаараа субъектив шинжтэй байх нь бий. Ач холбогдол, ашиг тус нь тухайн үйл явдал, зүй тогтлын дотоод бүтцээс шалтгаалахгүй, харин хүний нийгмийн оршихуйн хүрээнд хамаарах тодорхой шинж чанаруудын үнэлгээ юм. Хүн тэдгээрийн ашиг тусыг амьдрал, ахуйгаараа мэдэрдэг. Ингэхлээр **гаднах байдлаар үнэт зүйл нь аливаа объект, үзэгдлийн шинж чанар байдаг бол дотоод агуулгаараа мөн чанарыг илэрхийлдэг**. Ач холбогдол, ашиг тус нь тухайн объектын дотоод бүтцээс шалтгаалахгүй байгалиас заяасан шинж чанартай байдаггүй, харин хүний нийгмийн оршихуйн хүрээнд хамаарах тодорхой шинж чанаруудын субъектив үнэлгээ, тухайн хүн тэдгээрийг сонирхож, хэрэгцээ болгодогтой холбоотой.

Үнэт зүйлийн тогтолцоо бол байгаль, нийгэм, хүний амьдралд тохиолдож буй үйл явц, үзэгдлийн талаарх хүний үзэл бодол, байр суурийн төсөөлөл, чиг хандлагыг тусган илэрхийлдэг үнэт зүйлсийн цогц мөн. Тухайн ард түмэн, эзэн нь болсон хувь хүнээс өөр хэн ч санаа зовдоггүй асуудлын нэг бол үндэстний үнэт зүйлийн тогтолцоо нь юм. Үнэт зүйлийн тогтолцоо нь хүний объектив болон нийгмийн бодит байдалд өдөр тутмын удирдамж, хүрээлэн буй объект, үзэгдлүүдтэй түүний янз бүрийн практик харилцааг тодорхойлох үүрэг гүйцэтгэдэг. Ямар нэг зүйл янз бүрийн харилцаанд орж, өөр өөр зориулалтаар ойлгогддог, хэрэглэгддэг болохоор үндсэн агуулга нь өөрчлөгдөхгүй боловч янз бүрийн утгыг илэрхийлж болно.

Үнэт зүйлсийг үнэлэмжээс ялган ойлгож, хандах хэрэгтэй. **Үнэлэмж бол** субъектээс байгаль, нийгэм, хүний тодорхой үзэгдэл, үйлдэлд, бас ер бусын далд хүч зэрэгт сайн муу, сайхан муухай, зөв буруу, хэрэгтэй хэрэггүй, ашигтай ашиггүй, хүсмээр жигшмээр, мөрөөдмөөр салмаар гэх мэтээр өгч буй **үнэлгээ юм**.

Нийгэмд бий болсон хэм хэмжээ нь түүний үнэлэмжийн тогтолцооны хамгийн дээд илэрхийлэл юм (өөрөөр хэлбэл, сайн, зөв, хүсүүштэй гэж үзсэн санаанууд). Манай шинжлэх ухааны ном зүйд үнэт зүйл, үнэлэмжийг адилтгах, хольж хутгах, янз бүрээр орчуулах тохиолдол л ажиглагдах боллоо. Тухайлбал ШУА-ийн Философийн хүрээлэнгээс эрхлэн гаргасан Философийн шинэ нэвтэрхий толь бичигт үнэт зүйлийг үнэлэмж (хууд.1230-1233) хэмээн орчуулсан байна.

Түүнчлэн үнэт зүйл, хэм хэмжээний тухай ойлголт ч утга агуулгын хувьд ялгаатай. Үнэт зүйлс нь хийсвэр, ерөнхий ойлголтыг тусган илэрхийлдэг бол, хэм хэмжээ нь хэмжигдэхүйц утгатай, тодорхой нөхцөл байдалд хүмүүсийн зан үйлийг зохицуулах дүрэм, журам, удирдамжийн шинжтэй. Нийгэмд бий болсон үнэт зүйлсийн тогтолцоо нь хэм хэмжээний агуулгад нөлөөлдөг тул чухал үүрэг гүйцэтгэдэг. Бүх хэм хэмжээ нь нийгмийн үнэт зүйлсийг тусгасан байдаг. Иймд, нийгмийн харилцаанд бий болсон хэм хэмжээгээр үнэлэмжийн тогтолцоог дүгнэж болно.

Үнэт зүйл нь хүний үйл ажиллагааны бүх талбар, тал, амьдралын олон янз илрэлд, түүний дотор танин мэдэхүйн хүрээг хамардаг. Иймд, эдийн засгийн, улс төрийн, оюун санааны, ёс суртахууны гээд үнэт зүйлсийн тухай ярьж болдог.

Үнэт зүйлс боловсролтой холбогдох, өөрөө эрхэм үнэт зүйл болох тухайд. Үнэт зүйлс бол боловсролын үндэс суурь, голт зүрх, амин чанар байдаг бол боловсрол нь үнэт зүйлсийг тээгч, тэтгэгч, үнэт зүйлс бүхий хүнийг бүтээх эрдэм ухаан болдог. Энэ утгаараа боловсрол, үнэт зүйлсийг салгахын аргагүй хамаарал, шүтэлцээтэй.

Боловсрол нь түүний соёлын хүрээний өвийг бүрдүүлдэг ёс суртахуун, оюун санааны үнэт зүйлсийн нөлөөн дор бий болдог хүний оюун санааны дүр төрх гэж хэлж болно. Түүнчлэн хүнийг төлөвшүүлэх, өөрийгөө хүмүүжүүлэх, нөлөөлөх, өнгө зүс оруулах, өөрөөр хэлбэл хүн төрхийг бүрдүүлэх үйл явц юм. Хамгийн гол нь мэдлэгийн хэмжээ биш, харин хүний хувийн шинж чанартай холбож хослуулах, мэдлэгээ бие даан эзэмших, өөрийгөө удирдах чадвартай болох юм.

Үнэт зүйл философийн /боловсролын/ утгаар: Эртний стоицизмд үнэт зүйлсийн ойлголтод (Гр. *axios*) нэн ач холбогдол өгдөг байжээ. Үнэт зүйлс гэдэг нь тухайн үзэгдлийн субъектив ач холбогдол (ашигтай байдал)-ыг тусган илэрхийлдэг. Ингэж илэрхийлэхдээ, сайн сайхан эсвэл ашиг тусаас ялгаатай нь үнэт зүйл нь худал байж болно (La'ebrius, 2018).

Стоикчууд үнэт зүйлийн эсрэг нь адиафора (ялгаагүй байдал) хэмээх ойлголтыг хэрэглэдэг. Германы сонгодог гүн ухаанд үнэт зүйлсийн ойлголтыг Фридрих Ницше нэлээд ултай судалсан байдаг. Тэрбээр: “үнэт зүйлийг амьдралын чиг баримжаа (Werte)” хэмээн тодорхойлоод “үнэт зүйлийг дахин үнэлэх /переоценка/” үзэл санааг тунхаглав (Nietzsche, 2006).

Эртний стоицизмын нэгэн адил үнэт зүйлс нь субъектив эсвэл соёлын хувьд нөхцөлдсөн шинжтэй хэмээн үзэж байсан. Үнэт зүйлгүй байх нь үгүйсгэх үзлийг нөхцөл байдлыг бүрдүлдэг аж. Ницшегийн бүтээлүүдийн нөлөөгөөр философид үнэт зүйлсийн үзэл баримтлал өргөн дэлгэрсэн түүхтэй. Ухамсартай хүсэл зоригийг зохицуулагч болох үнэ цэнийн тухай гүнзгий судалгааг Бадены шинэ кантчуудын сургууль хийсэн байдаг. Тухайлбал Генрих Рикерт үнэн, гоо үзэсгэлэн, ариун байдал, аз жаргал, ёс суртахуун зэрэг үнэт зүйлсийг онцлон тэмдэглэв. Үнэт зүйлийг илэрхийлэх хэлбэр нь хэм хэмжээ, үнэлэмж байдаг (Rickert, 1921).

Олон улсын боловсролын эх сурвалж, бодлогын баримт бичгүүдэд **боловсрол нь үнэт зүйлд суурилсан байх шаардлагатайг** онцлон тэмдэглэж байна. Бодлогын баримт бичгүүдэд дурдсанаар: “Хүний амь нас, нэр төр, тэгш эрх, шударга ёс, соёлын олон төрөл, энх тайван, эв нэгдэл, хамтын хариуцлага, эрх чөлөө, хүний эрх, эрхэм чанар зэрэг **хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлд тулгуурласан мэдлэг, ур чадвар эзэмшүүлэхийг**; үнэт зүйлд суурилсан боловсролыг боловсролын бүх түвшинд бодлого, шийдвэрийн дэмжлэгээр хэрэгжүүлэхийг онцлон уриалж, зайлшгүй шаардлага болох”-ыг онцолжээ (Батзаяа Б., 2024).

ЮНЕСКО-гийн ISCED (Боловсролын олон улсын стандартын ангилал) -ийн тодорхойлсноор "боловсрол" гэсэн нэр томъёо нь мэдлэг эзэмших хэрэгцээг хангахын тулд хийгдэж буй чиглэсэн зорилготой, системтэй бүх төрлийн үйл ажиллагааг багтаадаг. Боловсрол нь өмнөх үеийнхний нийгмийн ач холбогдолтой мэдлэг, ур чадвар, туршлагыг хойч үеийнхэнд өвлүүлэх, дамжуулах нийгмийн зохион байгуулалттай, стандартчилагдсан үйл явц байдаг.

“Хүний эрхийн түгээмэл тунхаглал”-д **боловсрол үнэт зүйл болох суурь зарчмыг тодорхойлон:** “Хүн бүр сурч боловсрох эрхтэй...анхан шатны болон ерөнхий боловсрол үнэ төлбөргүй байвал зохино. Анхан шатны боловсролыг заавал эзэмшүүлэх ёстойг” дурдаад “Боловсрол нь бие хүнийг өв тэгш хөгжүүлэх, хүний эрх, үндсэн эрх чөлөөг улам бүр хүндэтгэдэг болоход чиглэх”, “аливаа улс түмэн, янз бүрийн арьстан хийгээд шашны бүлгүүд бие биеэ харилцан ойлгох, хүлцэн тэвчих, эвсэн найрамдах,... энх тайвныг сахиулах үйл ажиллагаанд дөхөм үзүүлэх” (26-р зүйл) үүрэг зориулалттай болохыг дурдсан байдаг. Энд боловсролын хэд хэдэн үнэт зүйлс дурдагдсан байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын “Сургалтын Луужин 2030” баримт бичигт суралцагчийн эзэмших мэдлэг, ур чадварын зэрэгцээ хандлага, үнэт зүйлсийн чухал үүргийг тодорхойлсон байдаг. Уг баримт бичигт тодорхойлсноор **үнэт зүйл нь “хувь хүний болон нийгмийн амьдралын бүхий л салбарт шийдвэр гаргахдаа баримталдаг итгэл үнэмшилд тулгуурласан, хүний үйл ажиллагааг чиглүүлдэг зарчим”** (OECD, 2019) хэмээн тодорхойлсон бөгөөд дэлхийн түвшин, улс орон, орон нутгийн онцлог ялгаатай нөхцөл байдалд нийцүүлэн авч үзэх боломжтой дараах дөрвөн ангиллыг дэвшүүлсэн байна. Үүнд, Тус баримт бичигт **үнэт зүйлийг хувь хүний үнэт зүйл, харилцааны үнэт зүйл, нийгмийн үнэт зүйл, хүн төрөлхтний үнэт зүйл** гэсэн дөрвөн үндсэн ангилалд авч үзсэн бөгөөд эдгээр нь суралцагчийн зан төлөв, нийгмийн оролцоо, дэлхийн иргэншлийн ухамсрыг төлөвшүүлэхэд чухал нөлөөтэй гэж үздэг.

Түүнчлэн “боловсролыг энх тайван, хүний эрх, нийгмийн шударга ёс, соёлын олон янз байдлыг хүндэтгэх үнэт зүйлсийг төлөвшүүлэхэд чиглэх ёстой гэж тодорхойлж, боловсрол нь суралцагчдыг дэлхийн иргэншлийн ухамсартай, хариуцлагатай оролцогч болгон төлөвшүүлэхэд чухал үүрэгтэйг онцолсон байдаг (UNESCO, 2015, pp. 14-15).

Боловсрол нь үнэт зүйл болох гаргалгааны философийн үндэс нь эртний Грекийн философийн уламжлал, хүний ёс суртахууны мөн чанар, сайн үйл, зөв амьдрах арга замыг боловсролын зорилго хэмээн үздэг байсантай холбоотой. Тухайлбал, Сократ” хүний амьдралын утга учир нь жаргал, ёс суртахуун, үнэнч байдал, зөв үйлийг эрхэмлэхэд оршдог” гэж үзэж, ёс суртахуунтай байх гэдэг нь гаднах нөхцөл байдлаар бус, харин дотоод ухамсар, итгэл үнэмшилд тулгуурлан зөв үйлддэг хүн хэмээн тодорхойлсон байдаг.

Платон боловсролыг хүнийг бүхэлд нь хөгжүүлэх үйл явц гэж үзэж, сайн үйлийн тухай философийг боловсролын цөм үзэл санаа болгон тодорхойлдог. Түүнийхээр сайн үйл нь танин мэдэхүйн үндэс бөгөөд үнэнийг танин мэдэх чадварыг нэмэгдүүлдэг байна. Платон боловсролыг оюун ухаан, ёс суртахуун, улс төрийн ухамсрыг нэгэн зэрэг төлөвшүүлэх цогц үйл явц (Романенко, хууд. 49) гэж үзсэн нь орчин үеийн үнэт зүйлд суурилсан боловсролын зорилго, чиг хандлагатай нийцдэг.

Английн философич, Нобелийн шагналт Бертран Рассел үнэт зүйлсийн талаарх буруу ойлголт, өрөөсгөл хандлагын тухай онолдоо ”Хоёр хүн нэг үнэт зүйлсийг ялгаатай үнэлж байгаа нь үнэний талаарх тэдний үзэл бодол нийцэхгүй байна гэсэн үг биш, ердөө л таалдаг, таашаадаг зүйлс нь өөр байгаа хэрэг” хэмээжээ. Түүний үзсэнээр “нэг үйлдэл нь нэг хүнд ашигтай (сайн) байхад, нөгөөд нь хортой (муу) байж болно. Тиймээс, бүх нөхцөлд нэг ижил үйлдлийг "нүгэл" гэж үзэн тамд шийтгэх нь шударга бус хэмээн (1927) дурдсан байдаг.

Орчин үед хүн төрөлхтний өмнө давхацсан олон хямрал, сорилтууд бий болж манай дэлхий эргэлтийн цэг дээр байгааг онцлоод тогтворгүй байдалд хөтөлсөн замаараа үргэлжлүүлэн яваад байх уу эсвэл чиглэлээ эрс өөрчлөх үү гэсэн сонголтын өмнө тулаад буйг анхааруулсан. Гэхдээ энэ амаргүй сорилтыг хохирол багатай даван туулахад **“бидэнд тулж босох гүн гүнзгий, арвин баялаг, олон янзын соёлын өв уламжлал бий. Хүмүүс агуу хамтын хүч нэгдэл, оюун ухаан, бүтээлч нөөц чадавхтай байдаг”** хэмээсэн нь тогтсон үнэт зүйлсэд тулгуурлан ажиллахыг зөвлөсөн хэрэг юм.

Уламжлалт нөөц боломж, хүчин зүйлс, арга хэлбэрээс гадна шинэ ойлголт, хандлага, үнэт зүйл тулгамдсан асуудлыг шийдэхэд тус болох учиртайг энэ бодлогын баримт бичигт дурдсан болно. тухайлбал, амьдралын туршид суралцахуй (learning throughout life), нийтийн боловсрол (public education), үндэсний иргэншил, хөгжлийн хүчин чармайлт, нийтлэг мэдлэг (knowledge commons), хүний болон хамтын хүний эрх (individual human right and collective human right), дэлхийг энэрэх нинжин (empathy), нигүүлсэх ариун (compassion) сэтгэлээр хувирган өөрчлөх оюун ухаан, нийгэм, ёс суртахууны чадавхыг тэтгэх хэрэгтэй. Түүнчлэн өрөөсгөл хандлага (bias), мухардмал зан заншил (prejudice), хуваагдмал байдал (divisiveness)-аас ангид байх нь чухлыг онцолсон байна.

Нийгмийн шинэ гэрээ нь бие даасан байдал, эрх чөлөөг дэмжиж, боловсролын ирээдүйн талаар олон нийтийн мэтгэлцээн, яриа хэлэлцээнд бүрэн хэмжээнд оролцох ёстойг онцлоод аливаа ялгаварлан гадуурхал (discrimination), орхин гадуурхалт (marginalization), хасан гадуурхалт (exclusion)-ын сорилтуудыг даван туулж, ялан дийлэх хэрэгтэйг ч анхааруулжээ.

Нийгмийн шинэ гэрээ нь боловсролыг нийтийн хичээл зүтгэл, ..нийтлэг сайн сайхан байдал буюу хамтдаа сонгож, хамтдаа хүрдэг сайн сайхан аж байдал (shared well-being) болгож бэхжүүлэхийг улс орнуудад уриалсан.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал “Алсын хараа 2050” баримт бичигт “Орчин үеийн шинжлэх ухааны арга зүйгээр нарийвчлан судалж, хөдөлшгүй баримтад үндэслэсэн “нэг хэл, нэг түүх, нэг соёл, нэг итгэл үнэмшлийг” нийт хүн амд төлөвшүүлж, үндэсний ижилсэл-ондоошлын гүн ухамсар дархлаатай үндэстэн улс байгуулахад тулгуур болохуйц **нэгдмэл үнэт зүйлсийг цогцлооно**” (Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал “Алсын хараа 2050”, хууд.91) гэж заасан байна. Энэ заалтыг бүх түвшний боловсролд анхаарч, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх нь нэн чухал асуудал юм.

Түүнчлэн монгол хүний язгуур үнэт зүйлс нь түүний бие бялдар, оюун ухаан, сэтгэхүй, сэтгэл-нийгэмшлийн өвөрмөц онцлог бөгөөд эдгээр нь биеийн хүч, хурд, хөдөлгөөний эвсэл,

саруул, холч ухаан, эр зориг, сониуч, ажигламтгай чанар, ерөнхийгөөс тусгай руу сэтгэх хэв маяг хийгээд энэрэн нигүүлсэх, эв эеийг хичээх, бусдыг хүндэтгэх, туслах, байгаль, амьтныг хүмүүнчлэн хайрлах сэтгэл, ёс суртахуун зэрэг үнэ цэнт үзүүлэлтүүдээр илэрч байгааг судалгаагаар харуулсан.

Монгол хүний үнэт зүйлсийн чухал онцлог бол дасан зохицох чадвар, тэсвэр тэвчээр, амьдралын хар ухаан, прагматик хандлага, нүүдэлчин ахуй, бие даан аж төрөх ёс, эрх чөлөөний мэдрэмж, хувийн үзэл бодол... болохыг тодотгосон болно Өөрөөр хэлбэл, Монгол үндэсний болон монгол хүний үнэт зүйлс нь Монгол үндэстэн, монгол хүн хэн бэ? гэдгийг илтгэж, таниулж, сэдэлжүүлж буй, тэрхүү үнэ цэнт, эрхэмлэлт зүйлүүдийн цогц, монгол хүний амин чанар (identity)-ын илрэл болой

Бидний монголчууд олон арван жил оршин тогтносон уламжлалт тогтолцооноосоо татгалзаж нийгмийн шинэ харилцааг сонгосон боловч **“нийгмийн оюун санааны амьдрал ихээхэн тодорхой бус, алаг цоог, зөрчил ихтэй** (ФСЭХ, 2014) хэвээр байна. Үүнийг дагалдаад **үнэт зүйлсийн агуулга, үнэлэмж, хэмжигдэхүүн ч ихээхэн өөрчлөгдөв.**

2024 онд батлагдсан “Монголын боловсролын тунхаглал” (Одхүү, 2025) бодлогын баримт бичигт **“Монгол улс боловсролын үнэт зүйлээ тодорхойлох нь боловсролыг өөрийн онцлогтой хөгжүүлэх үндэсний тэмүүллийн эх үндэс болно”** хэмээн үзэж монголын боловсролын үнэт зүйлсийг өөрийн нөхцөл байдал, хүрсэн түвшин, өвөрмөц онцлогт тохируулан шинээр томъёолсон байдаг. Тус баримт бичигт “үнэт зүйл нь хүн төрөлхтөн, нийгэм хүн хоорондын харилцаа, хувь хүн, үндэсний соёл, уламжлалд үзүүлэх боловсролын нөлөөлөл” болохыг онцлоод монголын боловсролын үнэт зүйл нь:-дэлхийн соёл, -хүн чанар, -гэр бүл, -суралцахуй, -монгол сэтгэлгээ байна хэмээн тодорхойлжээ. Энд чухамхүү боловсролтой холбоотой 5 суурь үнэт зүйлс нэрлэгдсэн байна.

Даяаршсан дэлхий ертөнцөд дэлхийн соёлд тулгуурлан хөгжихөөс өөр арга байхгүй нь ойлгомжтой. Гэхдээ өөрийн өвөрмөц онцлогоо хадгалан боловсролын үндэсний үзэл баримтлалтай болох, байхыг энэ баримт бичиг бүхэлдээ зориулагдсан болно. Хүн чанарын тухайд зөвхөн боловсролын төдийгүй ер нь үнэт зүйлийн цөм ойлголт мөн билээ. Либераль үзэл баримтлалыг сонгосноос хойш монгол хүний уламжлалт сайхан чанарууд бүдгэрч буй өнөөгийн нөхцөлд хүн чанарын асуудлыг боловсролын үнэт зүйлс болгон анхаарч буй нь зүй ёсны гэж үзнэ.

Суралцахуй бол боловсролын шинэ парадигм, өвөрмөц үнэт зүйл мөн. Боловсрол сургалтын 5 дахь тулгуур багана болон зарлагдсан суралцахуй бол бүн бүрийн эзэмшвэл зохих шинэ чадвар болоод байгааг харгалзан үнэт зүйлийн эгнээнд оруулсан нь цаг үеэ олсон

оновчтой зорилт, шийдвэрлэвэл зохих асуудал мөнөөс мөн. Өөрчлөлт шинэчлэлийг хүсч байгаа л бол сэтгэлгээ, хандлагаа өөрчлөхөөс өөр илүү зам үгүй. Тэр тусмаа хүнээр хүн хийж, эрдэм боловсролыг чухалчилж ирсэн монгол сэтгэлгээний шавхагдашгүй өв уламжлалаас суралцах, шинэ нөхцөлд бүтээлчээр хэрэглэх нь боловсролын хувирган өөрчлөлтийн нэг нөхцөл, үр нөлөө бүхий арга зам мөн юм.

Дүгнэлт

Бид энэхүү өгүүлэлдээ үнэт зүйлсийн талаар эх сурвалж, баримт бичгийн шинжилгээний арга ашиглан тодруулж, түүнийгээ боловсрол үнэт зүйл болох талаас монгол уламжлал, сэтгэлгээгээр хандан, авч үзсэн болно.

Үнэт зүйлс нь боловсролын утгаараа улс, үндэстний түүхэн хувьсал, хөгжлийн явцад бүтээж бий болгосон, өвлөж уламжлагдсан, тэтгэн дээдэлж, баяжуулан хөгжүүлж байх ёстой оюун санааны, сэтгэлийн болон эдийн дээд эрхэмлэлт зүйлийн цогц юм.

Боловсрол үнэт зүйлс болохын хувьд нийгэм, хувь хүний болон ерөөс аливаа юмс, үзэгдлийн бодит шинж чанар, түүний эерэг утга, жинхэнэ үнэ цэнийг илэрхийлсэн ойлголт юм. Иймд, хэн боловч үндэснийхээ үнэт зүйлд үнэмшиж итгэдэг, эрхэмлэн дээдэлдэг зан үйл, амьдралын зөв хэвшил, сурч боловсрохдоо сэдэл, удирдлага болгодог хөтлөгч баримтлал мөн.

Бид үнэт зүйлсийн агуулгыг, асуудлыг ойлгож, авч үзэхдээ ахуйд баригдан, материаллаг талыг нь илүү анхаарч, дотоод үнэлэмжтэй холбоотой, чухамдаа амин чухал талыг нь өрөөсгөл төсөөлж, дутуу орхигдуулж ирсэн гэм байна. Үнэт зүйлсийн ахуйн болон оюуны тал, тэдгээрийг тэнцвэржүүлэн нэгсүүлэгч амин чанарыг анхааран үзэх нь зүйтэй юм.

Хүн аливаад санаа бодол, байр сууриа илэрхийлэхдээ, сонголт хийх, шийдвэр гаргахдаа юуны өмнө өөрийн мэдлэг боловсрол, суурь үнэт зүйлсийнхээ баримтлал, тогтолцоонд тулгуурладаг.

Аливаа ард түмэнд тэргүүн зэргийн, цөм үнэт зүйл гэж байдаг. Бидний монголчууд эдийн соёлоос илүү оюуны соёлд түлхүү анхаарч, мэдлэг боловсролыг чухалчилж ирсэн билээ. "Эрдэм билиг эрхэм баян" хэмээх зүйр үгийг чухалчлан эрдэм мэдлэг, оюун ухаан, боловсрол нь хүний хамгийн чухал, юугаар ч сольшгүй, үнэ цэнээ алддаггүй үнэт зүйл гэж эрхэмлэж, боловсролын машид дээдэлдэг билээ.

НОМ ЗҮЙ

Bourdieu, P. (2003). Политическая онтология Мартина Хайдеггера: Praxis.

La'ebtrius, D. (2018). Lives of Eminent Philosophers (Vol. Book VII): Oxford University Press.

Nietzsche, F. (2006). Thus Spoke Zarathustra: A Book for All and None: Cambridge University Press.

Rickert, H. (1921). The Limits of Concept Formation in Natural Science: Cambridge University Press.

Аллак Ж. (1993). Вклад в будущее: приоритет образования. Педагогика, 166–168.

Багдасарьян Н.Г. (2008). Ценность образования в модернизирующемся обществе или ценность знания в обществе незнания. Педагогика(5), 9-18.

Батзаяа Б. (2024). Үнэт зүйлд суурилсан боловсролыг боловсролын бүх түвшинд хэрэгжүүлэх нь.

Дюркгейм, Э., & Гофман, А. Б. (1995). Социология: Ее предмет, метод, предназначение: Канон.

Зинченко В. В. (1997). О целях и ценностях образования Педагогика(5), 11.

Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал “Алсын хараа 2050”. (2019). Монгол Улсын засгийн газар Retrieved from <https://legalinfo.mn/mn/detail/15406>

Одхүү, С. (2025). Боловсролын антологи: Дэд дэвтэр (S. D. профессор, Б.Даш-Ёндон Ed.). УБ: Адмон принт.

Философийн шинэ нэвтэрхий толь (2022) УБ., -1632т

ШУА-ийн ФСЭХ. (2013). Монголын нийгмийн өөрчлөлт. (Нэмж засварласан 2 дахь хэвлэл) УБ.,